



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/92

Баян-Өндөр сум

**Ээлжит бус хуралдаан
зарлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 46.6 дахь хэсгүүд, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02/11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэг”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн Ээлжит бус XI хуралдааныг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр танхимаар зарлан хуралдуулж, дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр бэлтгэл хангасугай. Үүнд:

- 1.Хурлын байгууллагын болон Ёс зүйн хорооны дотоод асуудал
- 2.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай; (2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/32 дугаар тогтоол)

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус XI хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2026 оны 05 дугаар сарын 26-ны
өдрийн 4/26 дугаар захирамжийн хавсралт



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ БУС XI ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус XI хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

V/26-нд багтаан

Ажлын алба

2.Дотоод зохион байгуулалтын асуудлаар гарах шийдвэрийн төслийг боловсруулж Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

V/26, V/29, VI/04-ний дотор

Аймгийн ИТХ-ын Ёс хорооны дарга
Б.Мөнхдалай

3.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай; (2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 03/32 дугаар тогтоол) асуудлын илтгэл, холбогдох тооцоо, судалгаа, лавлагаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргаж Ажлын албанд ирүүлэх, Хурлын Зөвлөлийн болон Хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

V/26, V/29, VI/04-ний дотор

Аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр

4.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

VI/04-ний дотор

Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн
дарга Ш.Ганболд

АЖЛЫН АЛБА